

ОЛОН УЛСЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙ ДЭХ КОЛЛИЗИЙН АСУУДАЛ БА ТҮҮНИЙГ ШИЙДВЭРЛЭХ НЬ

МУИС, ОУХС-ийн багш,
докторант Б.Оюунчимэг

"Коллизи" гэдэг нь зөрчилдөөн, мөргөлдөөн гэсэн утгатай латин үг. Эрх зүйн онолын үүднээс "зөрчилдөөн" гэдэг нь нэг ижил харилцааг зохицуулж буй эрх зүйн хэм хэмжээнүүд агуулгаараа нийцэж зохицохгүй байхыг ойлгоно. Үүнээс болоод нэг ижил нөхцөл байдалд өөр өөр эрх зүйн үнэлэлт өгч, өөр өөрөөр шийдвэрлэх боломжтой гэсэн үг.

"Коллизи" нь зөвхөн олон улсын эрх зүйд гарч ирдэггүй, дотоодын эрх зүйд ч тохиолдоно. Гэхдээ энэ нь харьцангуй цөөн байх бөгөөд нэг улсын дотоодын эрх зүй дэх зөрчлийг үндсэн хууль болон тухайн улсын бусад эрх зүйн салбарын хүрээнд шийдвэрлэдэг. Гэтэл олон улсын иргэний эрх зүйд коллизийн асуудал нь түүний үндсэн агуулгыг бүрдүүлнэ. Учир нь олон улсын иргэний эрх зүйн харилцааны ихэнх нь зөрчлийг бий болгодог, өөрөөр хэлбэл аль нэг улсын материаллаг хэм хэмжээг шууд хэрэглэснээр зохицуулагдах боломжгүй.

Иймээс олон улсын иргэний эрх зүйн харилцааны үед ямагт гарч ирдэг Коллизи буюу зөрчилдөөнийг шийдвэрлэх хэрэгтэй болсон бөгөөд үүнийг улс орнууд олон улсын гэрээ юм уу, эсвэл үндэсний хууль тогтоомжоороо коллизийн хэм хэмжээг тогтоох замаар шийдвэрлэж байна. Зөрчилдөөний (коллизийн) хэм хэмжээ гэдэг нь гадаадын элемент бүхий тухайн иргэний эрх зүйн харилцаанд аль улсын хуулийг хэрэглэхийг заадаг хэм хэмжээг хэлнэ.¹

Зөрчилдөөний хэм хэмжээ нь онолын үүднээс багтаамж, холбоос гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. Зөрчилдөөний хэм хэмжээний багтаамж нь уг хэм хэмжээг хэрэглэх эрх зүйн харилцааг заадаг бол зөрчилдөөний хэм хэмжээний холбоос нь тухайн эрх зүйн

¹ Коллизийн хэм хэмжээг одоо хуулийн сургуулиудад зөрчилдөөний хэм хэмжээ гэж орчуулан хэрэглэж байна.

харилцаанд хэрэглэх хуулийг заана. Жишээлбэл, Зээлийн гэрээнд зээлдүүлэгчийн хуулийг хэрэглэнэ (ИХ 434§ 2.8) гэсэн зөрчилдөөний хэм хэмжээний багтаамж нь зээлийн харилцаа, харин холбоос нь уг харилцааг зохицуулах зээлдүүлэгчийн хууль юм. Зөрчилдөөний хэм хэмжээг ингэж бүтцээр нь задалж үзэх нь түүнийг ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангаж өгнө.

Зөрчилдөөний холбоосууд зөрчилдөөний хэм хэмжээний системийг бүрдүүлэх бөгөөд улс орнуудын хууль, практикт өргөн хэрэглэгддэг зөрчилдөөний дараах холбоосууд байдаг.

Lex personalis-(иргэний хувийн хууль) Иргэний чадвар, чадамж, хувийн статусыг тодорхойлоход хэрэглэдэг энэ холбоос нь дотроо *Lex patriae* (харьяалсан улсын хууль), *Lex domicilii* (оршин буй газрын хууль) гэсэн 2 хэлбэртэй. Улс орнууд аль нэгийг нь дагнаж, эсвэл хослуулан хэрэглэдэг. Манай улсын хувьд энэ 2 холбоос нь ИХ-ийн 428§2, 436§2-д тусгагдсан байдаг. Үүнд: "Гадаад улсын иргэний эрх зүйн чадамжийг түүний харьяалагдаж байгаа улсын хуулиар тодорхойлно" гэж 428§2-т заасан бол 436§2-т "Өвлүүлэгчийн иргэний эрх зүйн эрхийн чадвар, гэрээслэлийн хэлбэр, гэрээслэл хийх ба өөрчлөх асуудал нь уг гэрээслэлийг хийх ба өөрчлөх үед гэрээслэгчийн байнга амьдран сууж байсан улсын хуулиар тодорхойлогдоно" гэжээ.

Lex societatis-(хуулийн этгээдийн харьяалсан улсын хууль) Энэ холбоос хуулийн этгээдийн эрх зүйн чадвар, чадамжийг тодорхойлох бөгөөд манай ИХ-ийн 429§1-д, "Гадаад улсын хуулийн этгээдийн эрхийн чадварыг харьяалсан улсын хуулиар тодорхойлсныг тус улсад хүлээн зөвшөөрнө" гэж туссан байна.

Lex voluntatis-(талуудын сонгосон хууль) Талуудад хэрэглэх хуулиа сонгох боломж олгодог энэ холбоос ИХ-ийн 434§1-д "Гадаад эдийн засгийн хэлцэлд оролцогч талуудын эрх, үүргийг хэлцэл хийх үед болон түүнээс хойш хийсэн хэлэлцээрүүдээр талуудын сонгосон улсын хуулиар тодорхойлно" гэж тусжээ.

Lex rei sitae-(эд хөрөнгө байгаа газрын хууль) Өмчийн эрх зүй, өв залгамжлалын харилцаанд голлон хэрэглэгддэг уг холбоос нь ИХ-ийн 432§1, 3-т тусгагдсан байна. Үүнд: Уг зүйлийн 1-д, "Эд хөрөнгө өмчлөх эрхийг тухайн эд хөрөнгийн байгаа улсын хуулиар" 3-д, "Монгол улсын хуульд өөрөөр заагаагүй бол эд хөрөнгийн өмчлөх эрх үүсэх, дуусгавар болох асуудал нь ийнхүү өмчлөх эрх

үсэх, дуусгавар болох үндэслэл болсон үйл баримт, бусад нөхцөл байдал үүсэх үед тухайн эд хөрөнгө байсан улсын хуулиар тодорхойлогдоно" гэж тус тус заасан байна.

Lex loci contractus-(гэрээг байгуулсан улсын хууль) холбоос ИХ-ийн 433§1.3.5-д „Хэлцлийн хэлбэрийг түүний хийсэн улсын хуулиар тодорхойлно" гэж туссан.

Lex delicti commissi-(гэм хор учирсан газрын хууль) ИХ-ийн 435§1-д „Гэм хор учруулсны улмаас үүсэх үүргийн талуудын эрх, үүргийг нутаг дэвсгэр дээр нь гэм хор учруулсан үйл баримт буюу гэм хор арилгуулах тухай шаардлага гаргах үндэслэл болсон бусад нөхцөл байдал бий болсон улсын хуулиар тодорхойлно" гэж заажээ.

Lex loci activities-(үйл ажиллагаа явуулж байгаа газрын хууль) ИХ-ийн 434§2-д „...талууд хэрэглэх хуулиа сонгоогүй бол дор дурдсан талын оршин байгаа буюу үйл ажиллагааныхаа голыг явуулж байгаа улсын хуулиар тодорхойлно" гэж заагаад нийт 11 төрлийн гэрээнд хэрэглэх хуулийг тусгасан байна.

Lex venditoris-(худалдагчийн хууль) Энэ нь ИХ-ийн 434§2.2-т тусгагдсан „Худалдах-худалдан авах гэрээнд худалдагчийн талын хуулийг хэрэглэнэ”.

Lex fori-(шүүхийн хууль) ИХ-ийн 434§6-д „өмчлөх эрхээ хамгаалах тухай эд хөрөнгийн шаардлага гаргасан өмчлөгчийн эрхийг түүний сонгосноор уг эд хөрөнгө байгаа буюу түүнийг бүртгэсэн улсын, эсхүл шүүхэд нь нэхэмжлэл гаргасан улсын аль нэгнийх нь хуулиар тодорхойлно” гэж уг холбоосыг тусгасан байна. Дээр өгүүлсэн зөрчилдөөний хэм хэмжээнүүдийг харахад Монгол улсад зөрчилдөөний эрхзүйн систем бүрэлдэн тогтоод байна гэж хэлж болохоор байна. Зөрчилдөөний хэм хэмжээнүүд нь манай дотоодын хууль тогтоомжинд төдийгүй Монгол улсын Олон улсын гэрээ, эрүү, иргэн, гэр бүлийн хэргээр эрхзүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай гэрээнүүд Консулын Конвенцүүдэд агуулагдаж байдаг. Зөрчилдөөний хэм хэмжээг хэрэглэхийг жишээн дээр тайлбарлая.

Жишээ 1.

Монгол Улсын “Амар” ХХК-ний захирал Болд Хятад улсын иргэн Ван Янд 1000 тн хонины ноос худалдах гэрээг 1998 оны 6 сард

Улаанбаатарт байгуулжээ. Түүхий эдийн хагасыг буюу 5000 тн-ыг хугацаандаа нийлүүлсэн боловч үлдсэн хэсгийг 3 сар сунжруулсан. Үүнийгээ “Амар” компани зарим аймга, сумдын үер усны аюултай холбоон тайлбарласан боловч Ван Ян уг компанийг шүүхэд мэдүүлсэн байна.

Энэ тохиолдолд Монгол улсын, эсвэл Хятад улсын аль нэгнийх нь хуулийг дагнан хэрэглэхгүй бол эдгээр улсуудын материал хэм хэмжээнүүд зөрчилдөж, уг маргааныг хоёр өөр янзаар шийдвэрлэхэд хүргэнэ гэсэн үг, өөрөөр хэлбэл зөрчил бий болно. Харин Монгол Улсын хуулийг хэрэглэх үү, Хятад улсын хуулийг хэрэглэх үү гэдэг асуудлыг бид зөрчилдөөний хэм хэмжээний тусламжтайгаар шийдвэрлэнэ. Тухайлбал, Монгол улсын Иргэний хуулийн 434.2.1-д зааснаар “худалдах-худалдан авах гэрээнд худалдагчийн талын хуулийг хэрэглэнэ.” Дээрх жишээн дээр худалдагч тал нь Монгол Улсын иргэн учир Монгол улсын Иргэний хуулийн дагуу дээрх харилцааг зохицуулна гэсэн үг. Ингэж аль нэг талын хуулийг хэрэглэснээр 2 улсын хууль зөрчилдөх явдал үгүй болно. Үүнээс үзэхэд зөрчилдөөний эрхзүйн арга нь олон улсын иргэний эрхзүйн харилцааг зохицуулах гол арга болж байгаа боловч түүнийг хэрэглэхэд зарим нэг бэрхшээл гарч ирэх учраас төгс сайн арга болж чадахгүй байна.

Бид одоо ямар бэрхшээл гарч болохыг үзье.

1. Зөрчилдөөний хэм хэмжээг хэрэглэхийн тулд шүүгчид гадаад улсын хуулийг мэдэх шаардлагатай байдаг. Мэдээж дипломат болон консулын төлөөлөгчдийн байгууллагаар дамжуулан зөрчилдөөний хэм хэмжээний заасан улсын хууль тогтоомжийн талаар мэдээлэл олж авч болох боловч түүний агуулгыг тогтоох, тухайн улсад яаж хэрэглэж байгаагаар нь хэрэглэх зэрэг нь онол, практикийн тодорхой мэдлэг шаардана. Иймээс гадаадын хуулийг зөв хэрэглэж байгаа эсэх нь эргэлзээтэй. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд гадаад орнуудын хууль тогтоомжийг судалж, энэ чиглэлээр шүүгчдийг мэргэшүүлэх шаардлагатай болно.

2. Хуулийн зарим нэр томъёо, ойлголтууд нь улс бүрийн хууль тогтоомжоор өөр өөрөөр илэрхийлэгдэх явдал байдаг. Тухайлбал, “гэрлэлтийн хэлбэр”, “гэрээслэлийн хэлбэр”, “үл хөдлөх хөрөнгө” “эрх зүйн чадамж” гэх зэрэг хууль зүйн ойлголтууд нь янз бүрийн орны хууль тогтоомжинд агуулгаараа тэр бүр нийлж тохирдоггүй.

Тухайлбал, Монгол Улсын "Зохиогчийн эрхийн тухай" (1993) хуулиар "зохиогчийн амины эрх" гэсэн ойлголтонд нэрээ хэрэглэх, нэрээ дурддуулах, зохиогч байх гэсэн 3 эрхийг оруулсан бол зарим орны хуулиар эдгээрээс гадна „бүтээлээ нийтлэх, нийтлэгдсэн бүтээлээ эргүүлэн татах" гэсэн эрхүүд багтаж байх жишээтэй.

Заримдаа янз бүрийн орны хууль тогтоомж дах хууль зүйн ойлголт, нэр томъёо зүгээр нэг зөрөөд зогсохгүй өөр өөр салбар, институтэд хамаарагдах явдал байдаг. Ингэснээр тухайн харилцаанд ямар зөрчилдөөний хэм хэмжээг хэрэглэх вэ гэдгийг тогтооход бэрх болно.

Жишээ 2.

Оросын иргэн эмэгтэй өөрийн орондоо буюу Оросод амьдарч байхдаа охиндоо өв хөрөнгөө өвлүүлэх гэрээслэл бүчжээ. Дараа нь тэр Англид очоод Англи иргэнтэй гэр бүл болж, хүү төрүүлээд амьдралынхаа үлдсэн хугацааг тэнд өнгөрүүлсэн байна. Түүнийг нас барсны дараа 2 дах нөхрийн насанд хүрсэн хүү нь ээжийнхээ Оросод байгаа өв хөрөнгийг авахыг хүссэн боловч эхний нөхрийн хүүхдэд бүх өв хөрөнгийг өвлүүлэх тухай гэрээслэл байгаа учир түүнд уг өв хөрөнгийг олгохоос татгалзсан. Гэтэл хүү нь Английн хуулиар дахин гэрлэж байгаа тохиолдолд өмнө хүйсэн гэрээслэл хүчингүй болдог гэсэн үндэслэл гаргаж, өөрийн өвлөх эрхийг хүлээн зөвшөөрүүлэхээр шүүхэд хандсан байна. Иймээс шүүх хэрэглэх хуулийг сонгож гэрээслэлийг хүчинтэй эсэхийг тогтоох хэрэгтэй болсон.

Энэ тохиолдолд уг харилцаа нь өв залгамжлалын эрх зүйн харилцаа юу, гэр бүлийн эрх зүйн харилцаа юу гэдгийг тогтоосны дараа гэр бүлийн эрх зүйд хэрэглэдэг зөрчилдөөний хэм хэмжээг, эсвэл өв залгамжлалын харилцаанд хэрэглэдэг зөрчилдөөний хэм хэмжээг хэрэглэнэ. Харин аль зөрчилдөөний хэм хэмжээг хэрэглэх вэ гэдэг нь дахин гэрлэснээр өмнөх гэрээслэл хүчингүй болдог уг нөхцөл байдлыг гэр бүлийн эрх зүйн ойлголт гэж үзэх үү, өв залгамжлалын эрх зүйн ойлголт гэж үзэх үү гэдгээс хамаарна. Оросын хуулинд ийм ойлголт байхгүй бөгөөд гэрээслэлтэй холбоотой харилцаа өв залгамжлалын харилцаа байдаг. Оросын хуулийн дагуу "гэрээслэл бичих чадварыг" гэрээслэгчийн гэрээслэл бичих үедээ байнга оршин сууж байсан орны хуулиар тодорхойлох

бөгөөд энэ тохиолдолд Оросын хуулийг хэрэглэж гэрээслэл хүчин төгөлдөр болж хоёр дах нөхрийн хүү өвлөх эрхгүй болно.

Хэрэв Английн хуулиар уг ойлголтыг зүйлчилвэл дээрх нөхцөл байдал нь гэр бүлийн эрх зүйн ойлголт учир Оросын шүүх энэ тохиолдолд гэр бүлийн эрх зүйн зөрчилдөөний хэм хэмжээг хэрэглэх ёстой. Оросын гэр бүлийн хуулинд зааснаар гэрлэгсдийн хоорондын харилцааг тэдний байнга хамтран амьдарч байсан улсын хуулиар зохицуулна. Тухайн тохиолдолд гэрлэгсдийн байнга хамтран амьдарч байсан улс нь Англи улс учраас английн хуулиар маргааныг шийдвэрлэж, гэрээслэл хүчингүй болж, 2 дах нөхрийн хүү өв залгамжлахад хүрнэ.

Олон улсын иргэний эрх зүйн онолд ч, хууль шүүхийн практикт ч энэ асуудлын талаар нэгдмэл зохицуулалт бий болоогүй байна. Үүнийг шийдвэрлэх 3 арга байгаа боловч учир дутагдалтай байдаг.

1. Хууль зүйн ойлголтыг өөрийн хууль буюу lex fori зарчмаар зүйлчлэх². Энэ бол хууль зүйн ойлголтуудын зөрчлийг шийдвэрлэх хамгийн түгээмэл арга. Шүүгч зөрчилдөөний хэм хэмжээг хэрэглэхдээ гадаад улсын бүс өөрийн улсын эрх зүйн ойлголтыг ашиглана гэсэн үг. Гэвч энэ аргыг хэрэглэснээр гадаадын хуулийн агуулгыг гажуудуулахад хүргэж болно.

2. Хууль зүйн ойлголтыг тухайн эрх зүйн харилцаа бүхэлдээ холбоотой байгаа улсын хуулиар буюу lex causae зарчмаар зүйлчлэх³. Энэ нь эхний аргын дутагдлыг арилгах үүднээс гарч ирсэн. Иймээс энэ аргыг хэрэглэснээр гадаадын хуулийг гажуудуулах явдал гарахгүй боловч практикт тухайн харилцаа аль улсад илүү хамааралтайг тогтооход хүндрэлтэй.

3. Суулийн арга бол янз бүрийн улсуудын эрх зүйн системд нийтлэг байх нэгдмэл ойлголтуудын үндсэн дээр хууль зүйн ойлголтыг зүйлчлэх явдал. Үүнийг санаачилсан германы хуульч Э.Рабелийн үзэж байгаагаар улсуудын эрх зүйн ойлголтуудыг харьцуулан судалж нэгтгэх замаар ийм нэгдмэл ойлголтыг гаргана. Энэ аргыг мөн Оросын эрдэмтэн М.М.Богуславский дэмжиж байна.

² Энэ арга нь Германы хуульч Э.Бартен, Францын хуульч Франц Кан нарын нэртэй салшгүй холбоотой. Тэд анх энэ аргыг XIX зууны сүүлээр дэвшүүлж тавьжээ

³ Энэ аргын гол төлөөлөгч нь Английн хуульч М.Вольф бөгөөд 1950-аад оны үед гарч ирсэн арга юм.

Гэхдээ хууль зүйн нэгдмэл ойлголтыг яаж гаргах вэ гэдэг нь тодорхойгүй. Харьцуулан судлах замаар эрх зүйн эрдэмтдийн гаргасан ойлголт нь хуулийн хүчин чадалгүй. Харин ийм ойлголт нь улс орны хууль буюу олон улсын гэрээнд тусгагдсанаар л шүүх түүний хууль хэрэглэх үедээ иш татаж болно. Иймээс энэ бол улс орнуудын эрх зүйн системийн уг үндсийг хөндсөн ээдрээтэй арга. Хууль зүйн хувьд энэ аргыг зөвхөн олон улсын гэрээний хүрээнд хэрэглэх боломжтой. Тухайлбал, Бараа худалдах-худалдан авах гэрээний тухай Вений конвенцид тулгарагдсан ойлголтууд нь түүнд нэгдэн орсон орнуудын хувьд нийтлэг ойлголт байна.

Ихэнх улс хууль зүйн ойлголтыг зүйлчлэх асуудлыг хуулиараа зохицуулаагүй байдаг. Зохицуулсан нэг нь гол төлөв их for зарчмыг хэрэглэдэг. Тухайлбал, Алжир улс.

3. Зөрчилдөөний хэм хэмжээг хэрэглэх үед гарч болох бас нэг асуудал нь "буцааж заах" тухай асуудал.

Энэ асуудал нь XIX зууны сүүлчээс, тодруулбал 1878 оны Францын шүүхийн шийдвэрийн дараа олон улсын иргэний эрх зүйн онолд гарч ирсэн. Иймээс олон улсын практикт энэ нь "renvoi" гэсэн франц нэр томъёогоор нэрлэгддэг. Буцааж заах асуудал үүнээс өмнө 1841 онд Английн шүүхэд хэлэлцэгдэж байсан боловч тэр үед энэ нэр томъёо тархаагүй, түүнийг мэдэхгүй байв.

Буцааж заах асуудлыг ойлгуулах үүднээс түүний эхлэлийг тавьсан Англид хэлэлцэгдсэн хэргийн агуулгыг товчхон танилцуулах хэрэгтэй болов уу.

Жишээ 3.

Английн харьяат Раун гэч сүүлийн хэдэн жил Бельгид амьдарч байгаад 1829 онд нас барж, Бельгийн хуулийн шаардлагад нийцээгүй боловч Английн хуулиар хүчин төгөлдөр байх гэрээслэл үлдээжээ. Английн шүүхийн 1841 онд хэлэлцсэн хэрэгт гэрээслэлийн хүчинтэй эсэх асуудлаар маргаан үүссэн байна. Тэр үеийн Английн зөрчилдөөний хэм хэмжээний дагуу өв хөрөнөтэй холбоотой асуудлыг нас барагчийн нас барах үедээ байнга оршин амьдарч байсан улсын хуулиар зохицуулж байв, өөрөөр хэлбэл дээрх тохиолдолд энэ нь Бельги улсын хууль байна.

Гэтэл Бельгийн хуулинд гэрээслэлийн асуудлыг нас барагчийн харьяалсан улсын хуулиар зохицуулах тухай зөрчилдөөний хэм

хэмжээ тусгагдсан байсан нь эргээд Английн хуулийг хэрэглэхэд хүргэжээ.

Английн шүүх уг хэргийг шийдвэрлэхдээ хэрэв Бельгид шүүх худалдсан бол яаж шийдвэрлэх байсан яг тийм байдлаар шийдвэрлэсэн харин Бельгид байвал шүүгч Английн хуулийг хэрэглэх нь мэдээж.

Иймээс шүүх Английн хуулийг хэрэглэснээр гэрээслэл хүчин төгөлдөр үлдцээ. Энэ жишээнээс үзэхэд "буцааж заах" гэдэг нь аливаа харилцааг нэг орны хуулиар зохицуулахаар заасан байтал тэр орны хууль нь мөн уг хуулиар зохицуулахаар эргээд заах эсвэл 3-дагч улсын хуулиар зохицуулахаар заах замаар эхний заалтыг хүлээн авахаас таатгалзахыг хэлдэг байна.

Өнөөг хүртэл энэ асуудал нь бүрэн шийдвэрлэгдээгүй байгаа бөгөөд улс орнуудын хууль тогтоомж, шүүхийн практикт энэ талаар нэгдмэл чиглэл, хандлага тогтоогүй байна. Иймээс улс бүр буцааж заах асуудлыг өөр өөрөөр шийдвэрлэдэг. Манай улс энэ асуудлыг хууль тогтоомжоороо зохицуулаагүй орны тоонд ордог.

Зөрчилдөөний зөрчлөөс гарах түгээмэл 2 арга байна.

17. Энэ асуудалд анхаарал хандуулахгүйгээр үүссэн маргааныг зөвхөн өөрийн улсын зөрчилдөөний хэм хэмжээг хатуу мөрдөж шийдвэрлэх, өөрөөр хэлбэл өөрийн зөрчилдөөний хэм хэмжээ гадаадын хууль уруу заасан бүх тохиолдолд тэр улсын зөрчилдөөний хэм хэмжээг анхаарч үзэхгүйгээр зөвхөн материаллаг хэм хэмжээг хэрэглэх.

18. Гадаадын зөрчилдөөний хэм хэмжээг харгалзан үзээд, тухайн маргааныг хамгийн нийцэлтэй зохицуулах боломжийг эрж хайх өөрөөр хэлбэл хууль тогтоомж буюу практикт өөрийн хуулийг хэрэглэх үү, гадаадын улсын хуулийг хэрэглэх үү гэдэг асуудлыг шийдвэрлэх.

Энэ хоёроос гадна бас нэг арга байж болох нь Олон улсын зөрчилдөөний хуулийг батлаад улс бүрт адилхан байх зөрчилдөөний хэм хэмжээг бий болгох явдал юм.

Улс орнуудын зөрчилдөөний хэм хэмжээг ижилсгэхэд чиглэсэн олон улсын гэрээ, конвенцуудийг батлан гаргаад байгаа боловч эдгээр нь зөрчилдөөний хэм хэмжээний зөрчилтэй холбогдсон бүх асуудлыг шийдвэрлэхээр биш гэдэг нь мэдээж юм.

Эцэст нь тэмдэглэж хэлэхэд Монгол улсад олон улсын иргэний эрх зүйн тухай тусгай хуулийг батлан гаргаж, зөрчилдөөний асуудлыг зохицуулж өгөх цаг нэгэнт болжээ. Гадаад харилцаа өргөжин хөгжиж буй өнөө үед ийм хуулийг гаргахгүй бол нэг өдөр л манай шүүх мухардалд орох болно. Иргэдийнхээ эрх ашгийг хилийн чанадад хамгаалахад зөвхөн эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ хангалтгүй.

АЛТАН АРГАМЖ

197

IV. ДУРСАМЖ

МОНГОЛД АЖИЛЛАХ ТОМИЛОЛТОО ДУУСГААД...

1998-1999 онд БНСУ-аас Монгол
улсад сууж байсан Элчин сайд
Хван Гил Синий "Diplomacy"
сэтгүүлд нийтлүүлсэн дурсамж.

1999 оны 10 дугаар сар

Монгол орноос явахынхаа өмнө өнгөрсөн хоёр жил хагасын хугацаанд хийсэн ажлаа эргэж харахад төрийн албан хаагчийн хувьд идэвхитэй ажиллаж, амьдарч дээ гэсэн сэтгэгдэл төрж байна. Монголд ажиллана гэж зүүдлээ ч үгүй явсан би, томилолтын албаа дуусгаад Монгол явах болсноо сонсоод хүнд зурсан зураг гэж байдаг бололтой гэж бодсон билээ.

Би Монголд ирэхийнхээ өмнө Кувейтээс гадна гол төлөв Европын орнуудад Германд гурван удаа, Унгар, Шинэ Зеландад ажиллаж байв. Шинэ Зеланд хэдийгээр Номхон далайд орших боловч Европоос цагаачлан очсон хүмүүс их байдаг учир Европтой адилтган үздэг. Миний дипломатчийн ажил амьдралын нэг хэсэг хугацаа Монголтой холбогдох юм гэж тэр үед санасангүй явжээ. Улаанбаатар дэлхийн хамгийн хүйтэн хот өдөр, шөнө, өвөл, зуны цаг агаар нь эрс тэс учир гадны хүмүүс эрүүл мэнддээ онцгой анхаарах хэрэгтэй юм. Тиймээс ч энд суугаа хөгжингүй орны дипломатууд жилдээ 2-3 сар нутагтаа очиж амардаг.

Монголын цаг агаарт харьцангуй амархан дасдаг гэх Солонгосчууд ч 3-4 жил болоход өөрөө ч мэдэлгүй бие нь муудаж, урьд өмнө байгаагүй харшиллын өвчтэй болж шаналах хүмүүс цөөнгүй байдаг.

Би Монголд томилогдсоноо надад ногдсон хувь тавилан хэмээн бодож амьдралдаа идэвхитэй, зориг тэвчээртэй байж ажиллахаар шийдсэн. Бэрхшээлийн өмнө өвдөг сөхөрч унжтар байх юм бол улам дордоно гэдгийг ажил амьдралынхаа туршлагаас мэдэж байв.

"Довтолгоон бол хамгийн сайн хамгаалалт" гэсэн үг байдаг даа.

Хван Гил Син

"Монгол ажиглах томилолтоо дуусгавал..."